

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ , ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг: Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Мянганы хөгжлийн цогц бодлогод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан стратегийн 124 зорилтоос тус аймагт хамааралтай 55 зорилтыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн явц 2009 онд төлөвлөсөн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн байдлаар тооцоход 82.7 хувьтай байна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж үзэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний аймагт холбогдох 92 зорилт 159 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2009 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган сум, хэлтэс агентлагуудын нэр дээр бүртгэл хяналтад авч хэрэгжилтийг явцад хагас жил дутам хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажилласан. Төлөвлөгөөний 47 заалт 2009 онд төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд бүрэн хэрэгжиж байгаа, 40.3 хувь нь 70-90 хувьтай, 47 арга хэмжээ буюу 29.6 хувийн хэрэгжүүлэх хугацаа болоогүй, **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт** 2009 оны зорилтын хүрээнд тооцож үзэхэд тус аймагт 92.1 хувьтай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд багийн эмч бэлтгэх арга хэмжээ авсанаар энэ онд 18 багийг бага эмчтэй болгосон, “Тогтвортой амжиргаа” төслөөр 42 багийн эмчийг унаажуулах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, аймгийн хүүхдийн цэцэрлэгүүдийг тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангахад 323.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн, “Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш нарыг урамшуулах журам” –ыг аймгийн Засаг даргын 2009 оны 42 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж 15 багшийг аймгийн шилдгээр шалгаруулан жилийн цалингийн 10 хувьтай тэнцэх мөнгөн урамшил олгож эхэлсэн, ЕБС-ийн багш нарыг сургууль дээрээ мэргэжил боловсролоо тасралтгүй дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж сургууль бүрийг “Багшийн хөгжлийн төв”-тэй болгосон, Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 10 сургууль, 14 цэцэрлэгт 116.1 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийн тохижилт хийсэн, аймгийн хэмжээний 12976 өрхийн амьжиргааг тогтоон мэдээлэлийн сан бүрдүүлж халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийг тогтоосон зэрэг нааштай үр дүн гарч эхэлсэн байна.

Мөн Цахилгаан дамжуулах агаарын 10, 15, 35 кВа-ын шугамын дагуух багийн төв, малчин өрхүүдэд жижиг трансформаторын дэд станцаар цахилгаан буулгах туршилтын ажлыг 18 цэгт /багийн төв, малчдын өвөлжөө, тариалангийн худаг гм/ хийж, ашиглалтад хүлээн авсан, ХХААХҮЯ-ны 5,7 сая төгрөгийн санхүүжилтээр Хулд сумын “Төгрөгийн итгэлцэл” хоршоо ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулан савлах цех байгуулж жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх аймгийн жишиг сум болж ажиллаж байгаа, 28,0 га-д

малын тэжээл тариалж, 100 сая төгрөгөөр 185.6 мянган метр бэлчээр хаших тор бэлтгэж, 5 суманд усалгааны жижиг систем барьсан, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 суманд бэлчээр усжуулах, ногоо тарих зориулалтаар инженерийн хийцтэй 11 худаг шинээр гаргаж ашиглалтад хүлээж авсан, 15 сумын 82 цэгт газрын доорхи усны хайгуул хийж, 29 цэгт ашиглалтын цооног, 28 цэгт хайгуулын цооног өрөмдөх боломжтой болсон, БНСУ-ын Гуяан хотын захиргаа, “Ногоон Ази” ТББ-ын тусламжаар аймгийн төвд “Гуяаны төгөл”-ийн 5 га талбай хашиж, 5000 суулгац суулгасан, аймгийн төвд 10 га газар хашиж, гүний худаг гарган МҮСТ-д туршилтын талбайн зориулалтаар хүлээлгэн өгч 2000 ш мод тарьсан, бүх сумд төвдөө цэцэрлэгт хүрээлэнтэй болохоор 1-3 га газар хашиж мод тарьж эхэлсэн байна.

Тус аймагт Засгийн газрын үндэсний 71 хөтөлбөр, 5 төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрийг сум, хэлтэс агентлагуудын нэр дээр бүртгэл хяналтад авч хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Хөтөлбөр, төслүүдийн биелэлтийг Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолоор баталсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2009 оны байдлаар тооцож үзэхэд хөтөлбөрийн биелэлт 92.3 хувьтай, хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээс хойш хийсэн ажлын явц байдлаар тооцоход 82.5 хувьтай, төслүүдийн хэрэгжилт 97.5 хувьтай байна.

Үндэсний хөтөлбөрүүдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний гурав дахь хөтөлбөр, Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, Морин хуур уртын дуу, Ногоон хэрэм, Цөлжилттэй тэмцэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт тус аймагт бусдаасаа ахицтай байна. Харин Арьс шир, Шингэрүүлсэн шатдаг хий, Монгол хөөмий, Монгол уламжлалт бий биелгээ, Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, Авлигатай тэмцэх, Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашралтай байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийн явц байдлаас үзэхэд эрүүл мэнд, боловсрол, соёлын хөтөлбөрүүдээс бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал орон нутгийн төсөвт тусгагдаж чаддаггүйгээс гол төлөв гадаад, дотоодын төслийн болон ТББ байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа байдалтай байна.

Хоёр.Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймагт холбогдох 94 зорилт арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулав.

Монгол улсын эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймагт холбогдох зорилт арга хэмжээний хэрэгжилт 96.2 хувьтай байна.

Эмзэг бүлгийн орлого багатай 50 өрхийн амьжиргаа дээшлүүлэх зорилгоор 4 өрхийг ХЭДС-ийн жижиг зээлэнд, 16 иргэнийг мэргэжил олгох сургалтанд, 11 өрхийг малжуулахаар мянгат малчныг дагалдуулж, 2 хүнийг хамаатан саданд нь, 5 иргэнийг

ажилд зуучилж, 8 өрх ноосны цехтэй болж, ногоо тарих болон ус, хог зөөвөрлөхөд 4 өрхийг тус тус ажиллуулан, амьжиргааг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэв

“Говийн ирээдүй” цогцолбор сургуулийн 80 хүүхдийн дотуур байрыг шинээр барьж Өндөршил, Хулд, Адаацаг, Өлзийт сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийж сэргээн засварласнаар дотуур байрны хангамж нэмэгдэн, дотуур байранд суух хүүхдийн тоо өмнөх оноос 2.5 хувиар нэмэгдсэн бөгөөд **дотуур байранд суух хүүхдийн хамрагдалт 101.9 хувьд** хүрсэн байна.

Хүүхэд бүрийг компьютержүүлэх төсөл тус аймгийн зарим сургуулийн 2-5 дугаар ангийн сурагчдын хүрээнд хэрэгжиж эхлээд 189 сурагчид 46.4 сая төгрөгийн компьютер олгогдож, түүнийг ашиглах, үрэгдүүлэхгүй байх талаар ангийн багш, эцэг эх, сурагчидтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Бага насны хүүхдийн авьяас чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэдэх урлагийн бага танхимыг тохижуулан Хүүхдийн театр болгож, театрын дугуйландаа 12 хүүхдийг шалгаруулан авч хичээллүүлж эхлэв.

Багийн төвийн цахилгаан хангамжийн байдал судалгаа хийж үзэхэд тус аймгийн **нийт 64 багийн 45 нь буюу 70.1 хувь нь цахилгааны ямар нэг үүсвэртэй** болсны дотор Цагаандэлгэр сумын 2-р баг, Сайхан-Овоо сумын Онги, Сайнцагаан сумын Наран, Говь-Угтаал сумын Морьт багуудын төвд жижиг трансформаторын дэд станцаар өндөр хүчдэл буулгасан байна.

2009 онд 10 сумын нутагт малчид, иргэд 29 гар худаг гаргаж, аймгаас энэ ажилд 17,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж урамшуулав.

“Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн жишиг аймаг” болох хөтөлбөр боловсруулан аймгийн Засаг даргын 2009 оны 303 тоот захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Адаацаг, Гурвансайхан, Баянжаргалан, Өндөршил сумдад шилэн кабель суурилуулах ажлын зураглал хийгдэж, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт сумдад шилэн кабель тавих тендер зарлагдаж БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай ZTE компани шалгаран 2010 ны эхний хагаст гүйцэтгэхээр болоод байна.

Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд урьд онуудад байгуулсан ойн зурвасуудын арчилгаа, тордолгоог хийж, шинээр Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан сумдад **12.5 га** талбайд 6173 ш мод тарьж, ойжуулалтын ажил хийж, 94.5 хувийн ургалтын хувьтай хүлээж авсан. 2009 онд Дэрэн, Баянжаргалан, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Говь-Угтаал зэрэг сумд төвдөө мод тарьж цэцэрлэг хүрээлэн байгуулж эхэлсэн, 15 суманд 31841 мод тарьж ургуулсан байна

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс УБ-Мандалговь -Тавантолгой – Оюу толгойн 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө, УБ-Мандалговь-Даланзадгадын 200 км авто зам барьж эхлэх, ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүн борлуулах биржийн сүлжээ бий болгох зэрэг асуудлууд санхүү эдийн засгийн хямралт байдлаас шалтгаалан санхүүжилтийн асуудал шийдээгүйгээс хэрэгжилт нь удааширч бодитой ажил болж чадсангүй.Түүнчлэн малчдад бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлэх асуудал хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс хэрэгжиж чадаагүй, тасарсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 206 заалтаас 2009 оны байдлаар 173 зорилт, арга хэмжээний биелэлтийг тухайн жилийн зорилт арга хэмжээний

төлөвлөгөөний биелэлтээр тооцоход 95.7 хувьтай байна. Хугацаа болоогүй 33 заалт байна.

Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд боловсруулсан “Аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөө”-ний хэрэгжилт 92.9 хувьтай байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгагдсан мах боловсруулах үйлдвэр, УБ-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай автозам, УБ-Мандалговь-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220 кВт-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц барих зэрэг аймаг орон нутаг төдийгүй бүс нутгийн ач холбогдолтой томоохон арга хэмжээнүүд хөрөнгө мөнгөний дутагдалтай байдлаас болж хэрэгжсэнгүй.

Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, хүний хөгжлийг дэмжин иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад чиглүүлэн боловсролын салбарт 884.6 сая, эрүүл мэндийн салбарт 396.9 сая, соёлын салбарт 259.4 сая төгрөгийн хөрөнгө оруулсан байна.

Энэ онд Баянжаргалан, Дэрэн сум, Сайнцагаан сумын 4 дүгээр сургуулийн спорт заал, Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 80 хүүхдийн дотуур байр шинээр барьж, 4 сумын сургуулийн хичээлийн байр, 3 сумын сургуулийн дотуур байр, 2 сумын хүн эмнэлэг, БГХӨТТөв, Эрүүл мэндийн газрын барилгад их засвар хийж, 2 сумын 3 цэцэрлэгийн барилгад засвар хийж, 3 сумын сургууль цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэн, 8 сумын эмнэлгийн цэвэр усны эх үүсвэрийн хайгуул, гүний худгийн угсралтын ажлыг хийж, эмнэлгийн цэвэр усны хангамжийг сайжруулжээ.

Ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлсэнтэй холбогдуулан 6 настай хүүхдийн сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлж, “Боловсролын хөгжлийн хөтөлбөр- 2”, Дэлхийн Зөн ОУБ-ын санхүүжилтээр Ерөнхий Боловсролын 18 сургуульд 50 багц хичээлийн хэрэглэгдэхүүн, 24 бүлгийн ангийг сурагчийн иж бүрэн ширээ сандал тоног төхөөрөмжөөр хангаж, 7 цэцэрлэгийн бие засах газрыг эрүүл ахуйн шаардлага, бага насны хүүхдийн стандартад нийцүүлсэн байна.

Сургуулиудад үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс ерөнхий боловсролын 6 сургууль, 7 цэцэрлэгт “Тогтвортой амьжиргаа” төслийн 77.5 сая төгрөгийн санхүүжилтээр, 4 сургуульд “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төслийн 12,7 сая төгрөгийн санхүүжилтээр, 7 цэцэрлэгт сургууль улсын төсвийн 25.9 сая төгрөг нийт 10 сургууль, 14 цэцэрлэгт 116.1 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийн тохижилт хийсэн нь нийт сургуулийн 55.5%, цэцэрлэгийн 70%-ийг эзэлж байна.

2009 онд нийт сургуулийн 66.7 хувь нь интернэтэд холбогдсоноос 44.6 хувь нь өндөр хурдны байнгын интернэттэй болж, багш, сурагчдын мэдээлэл шуурхай авах боломж нөхцөлийг бүрдүүллээ.

Тайлант онд 6 настай хүүхдийн хамралт 81.7, бага боловсролын хамралт 83.8, суурь боловсролын хамралт 82.8%-д хүрсэн нь сүүлийн 2 жилийн дунджаас 1.3-2.4%-иар өссөн амжилттай байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 87.6, цэцэрлэгийн хамралт 62, бичиг үсэг тайлагдалт 97.9%-тай байна.

Өнгөрсөн хичээлийн жилд МСҮТ-д “Ойжуулалт цэцэрлэгжүүлэлт, хүнсний ногооны аж ахуй”-н мэргэжлийн анги шинээр нээж, мод үржүүлгийн туршилтын талбайтай болго—лоо.

“Соёлын төв-чанартай үйлчилгээ II” улсын уралдаанд Эрдэнэдалай сумын соёлын төв 3-р байрт шалгарч, “Батламж”, 2 сая төгрөгөөр, аймгийн “Загвар соёлын төв” шалгаруулах болзлыг Өндөршил сумын соёлын төв хангаж “Батламж”-ийн эзэн болсон. “Ахмад уртын дуучид, морин хуурчдын шавь төрүүлэх ажлыг дэмжих” аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, нийт 9 сумын 21 ахмад авьяастнуудтай гэрээ байгуулан, сургалт явуулах эрх олгон тайлан тоглолт хийж, үр дүнг тооцож байна.

Бага насны хүүхдийн авьяас чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэх үүднээс Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд “Хүүхдийн театр” байгуулан, 14 төрлийн дугуйланд 200 гаруй хүүхдийг хамруулаад байна.

Энэ онд 5 сумын эмнэлгийг магадлан итгэмжлэлд хамрагдаж, нэгдсэн эмнэлгийн амбулаторын хэт авиа оношилгооны кабинетыг иж бүрэн компьютер, ЭХО хувилагчтай болгосноор үйлчилгээний түргэн шуурхай байдал хангагдлаа.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар 2005-2010 онд баримтлах бодлогын хүрээнд хөдөө сумдад 1-ээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 27 их эмчид 13.5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов.

“Тэгш дүүрэн хөтөлбөр”-ийн хүрээнд 3 сумын хөгжлийн бэрхшээлтэй 15 өрхөд 300 толгой ямааг төмөр сүргийн хэлбэрээр олгосон ба зээлийн эргэлтийн сан байгуулан 13 зээлдэгчид 7.3 сая төгрөг, мөн жижиг төслүүдээр 8.8 сая төгрөг олгож, орлогыг нь нэмэгдүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2009 онд 23 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 42.1 промилль болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.9 промиллоор, халдварт шар өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеэс 14.6 промилоор буурчээ.

Өрх хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 315 иргэнд 1.1 тэрбум төгрөгийн жижиг зээл олгож, 634 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нь нэмэгдүүллээ.

“Өрх хүн амын амьжиргааны түвшинг тогтоох, үнэлэх” аргачлалын дагуу аймгийн хэмжээний 12976 өрхийн амьжиргааны түвшинг тогтооход чинээлэг өрх 1.9%, боломжийн өрх 11.9, дундаж өрх 57.1, ядуу өрх-25.0, нэн ядуу өрх 4.1%-тай байна гэсэн судалгаа гарсан бөгөөд өнгөрсөн оноос ядуу, нэн ядуу өрхийн тоо 0.9 хувиар буурсан дүнтэй байна.

Энэ онд барилгын засал чимэглэл, цахилгаан монтаж, гагнуур, сүлжмэл, бэлэг дурсгал, арьсан урлал, гэр ахуйн цахилгаан хэрэгслэлийн засвар, гэрийн асаргаа үйлчилгээ зэрэг 18 төрлийн сургалтад 439 иргэнийг хамруулж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүллээ. Сургалтад хамрагдсан иргэдийн 281 нь байнгын ажлын байраар хангагджээ.

“Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд 100 ноосны цехийн ахлагчдын туршлага солилцох уулзалт зөвлөлгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, МХАҮТ-аас зохион байгуулсан “Эко Монгол” гар урлалын үзэсгэлэнгээс 9 нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх

зураасан кодын эрх авсны дээр уг бүтээгдэхүүнүүд нь “Дундговь-Түншлэл 2009” үзэсгэлэн худалдаанд “Шилдэг гар урлалын бүтээгдэхүүн”-ээр шалгарлаа.

“Өрх бүр үйлдвэрлэгч, үйлчлэгч хөдөлгөөн-2” хөдөлгөөний хүрээнд тодорхой арга хэмжээнүүд авч ажилласнаар **819 хүнийг байнгын, 1491 хүнийг түр ажлын байраар хангаж, ажилгүйдлийн түвшин 2.4 хувьд хүрсэн нь улсын дунджаас 0.9 хувиар доогуур түвшинд байна.**

2009 онд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид 1007 хүн хамрагдаж 439.1 сая, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 18332 хүүхэд хамрагдан 630.9 сая, шинээр төрсөн 1249 хүүхдэд 124.9 сая, шинээр гэр бүл болсон 660 өрхөд 330.0 сая, 3252 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт үйлчилгээнд 252.7 сая төгрөг тус тус зарцуулав.

УИХ-ын 2009 оны 39-р тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, уг бодлогыг хэрэгжүүлэх Засгийн газрын 2009 оны 208-р тогтоолыг үндэслэн 2009-2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний аймгийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Энэ хүрээнд аймгийн малчин залуучуудын “Шинэ зууны малчин залуус” 2-р чуулганыг ХААН банк, Мерси Кор ОУБ-тай хамтран Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдад бүсчлэн 170 гаруй малчид, залуучуудыг хамруулан зохион байгуулж, нийт малчид, малчин залуустаа хандсан уриалга гаргасан бөгөөд энэ үеэр өрхийн орлогоо нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэх, малын үүлдэр угсаагаа сайжруулах зэрэг чиглэлээр хэд хэдэн төрлийн сургалтуудыг зохион байгууллаа.

Дээрх бодлого төлөвлөгөөнд туссан малчдын эрүүл мэндийн талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй ажлын 2 хэсэг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг 32 цэгт төвлөрүүлэн 3500 орчим малчдыг хамруулан зохион байгуулсан нь алсын оторт яваа малчдаа эргэх, тэднийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулсан үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Улсын төсвийн 225 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 суманд мах хөлдөөх хөргүүр бүхий 18 чингэлэг суурилуулснаар хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан махаар хангах нөхцөл бүрдүүлсэн

Бэлчээр хаших болон мод, төмс хүнсний ногоо тариалах санал санаачилга гаргасан иргэд, малчдыг дэмжих зорилгоор 100 сая төгрөгийн хөрөнгөөр 185580 м тор аваад байгаа бөгөөд шонгоо түгжиж бэлэн болгосон малчдад олгож эхлээд байна. Энэ тороор нэг өрх 3-аас доошгүй га бэлчээр хашна гэж тооцоход 300 гаруй өрх 1300 гаруй га бэлчээр хаших боломжтой болох юм.

Тогтвортой амьжиргаа-2 төслөөр бүх суманд бэлчээр хаших, худаг гаргах, тэжээлийн ургамал тариалах 70 төсөлд 199,4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, тендер нь зарлагдаж, материал нийлүүлэгдэхээр болоод байна.

2009 онд 55,2 га-д төмс, 17,9 га-д хүнсний ногоо, 7,8 га-д жимс, жимсгэнэ, 28,0 га-д малын тэжээл тариалж, 460,4 тн төмс, 73,2 тн хүнсний ногоо 1,0 тн чацаргана, 6,9 тн малын тэжээлийн ургамал хураан авсан нь тариалсан талбайн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 30 гаруй хувиар, хураан авсан ургац 2 дахин өсчээ.

“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-д “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн зээлд хамрагдахаар 254 аж ахуйн нэгж, иргэд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх төслөө ирүүлснээс шаардлага хангасан 118 төслийг “Монгол шуудан” банкинд хүргүүлснээр одоогоор 46 зээлдэгчид 771,7 сая төгрөгийн зээл олгогдож, зээлийн ашиглалт 98.9 хувьтай байна. Үүний үр дүнд **16 шинэ үйлдвэр бий болж, 207 байнгын, 53 түр ажлын байр шинээр нэмэгджээ.**

ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй “Францын хүнсний тусламжийн сангийн зээлийн төсөлд 3 ААН, 5 иргэн хамрагдаж 51.4 сая төгрөг, ХААН, ХАС, МШБ-уудад байршуулсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлээс 281.2 сая төгрөгийг 259 зээлдэгчид олгожээ. ХХААХҮЯ-ны 5.7 сая төгрөгийн санхүүжилтээр Хулд сумын “Төгрөгийн итгэлцэл” хоршоо ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулан савлах цех байгуулан бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлж эхлээд байна.

“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-д “Дундговь-Түншлэл-2009” арга хэмжээгээ уламжлал болгон зохион байгуулж 15 сумын 199 ААН, байгууллага, иргэд 21 нэр төрлийн бүтээгдэхүүнтэй оролцон, 55.3 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Үзэсгэлэн худалдаанд оролцсон бүтээгдэхүүнийг 10 номинацаар шалгаруулахад Дэлгэрхангай сумын Ц.Даваагийн хөмүүлтэй аарц, Адаацаг сумын Л.Бат-Эрдэнийн гүүний айраг, Хулд сумын “Төгрөгийн итгэлцэл” хоршооны сүү, сүүн бүтээгдэхүүнүүд “Аймгийн брэнд” бүтээгдэхүүний гэрчилгээ авснаар аймаг хэрэглэгчдийн таашаалд нийцсэн нийт **27 нэрийн брэнд бүтээгдэхүүнтэй** болоод байна. Эдгээр брэнд бүтээгдэхүүнээс Мандалговь Хүнс ХХК-ны ингэний сүүн бүтээгдэхүүн төвийн бүсийн брэндээр шалгарлаа.

Говь-Угтаал сумын Төмөртэйн ордод баяжуулах үйлдвэр, ажилчдын байр, уурхайн тосгоноо байгуулж, цахилгаан шугам сүлжээнд холбогдож, олборлолтын үйл ажиллагаагаа эхэлж, Говь-Угтаал сумын Хараатын ордын эрэл хайгуулын ажил дуусч, үйлдвэрлэлийн зориулалттай ашиглагдах усны хайгуул хийгдэж байна. Эрээний төмрийн ордын ерөнхий эрэл хайгуул дуусч, техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөөгөө батлуулахаар холбогдох газруудад хүргүүлээд байна.

Мөн Сайнцагаан сумын Лог үнстийн нүүрсний уурхай ашиглалтад орсноор нүүрсээр хангагч аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнөөс нүүрсний үнэ тогтвортой байх нөхцөл бүрдлээ.

“Үйлдвэржүүлэлтийн жил”-ийн хүрээнд аймгийн арилжааны банкууд 26271 зээлдэгчид 14.5 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Банкны системд шинэ дэвшилтэд технологи, сүлжээ өргөн нэвтэрч хамгийн сүүлийн үеийн технологи Мобайл банкны “Амар” үйлчилгээ Хас банкинд нэвтэрч, 20 гаруй агенттай болжээ.

Төрийн захиргаа, хууль эрх зүйн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож, төр, иргэний нийгмийн түншлэлийг өргөжүүлж, гадаадын улс орнуудтай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, хууль тогтоомжийг сахиулж, сахилга, дэг журмыг сайжруулах зорилт дэвшүүлэн ажиллаж ирлээ.

2009 оныг “Төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, жилийн ажлыг зохион байгуулах тухай 02 тоот захирамж гарган ажлын хэсэг томилж, жилийн ажлын төлөвлөгөөтэй ажилласан.

Жилийн ажлын хүрээнд **“Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага-манлайлал” сэдэвт** аймгийн зөвлөгөөн зохион байгуулж, аймгийн нийт төрийн албан хаагчдад хандсан “Уриалга”, аймгийн Засаг даргын албан даалгавар гарган, хэрэгжилтийг зохион байгуулав.

Жилийн ажлыг зохион байгуулах комиссоос аймаг, сумын төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх ажлын шалгуур үзүүлэлтийг улирал бүр шинэчлэн гаргаж, шалгуурын дагуу сум, байгууллага, хэлтэс агентлагийн ажлыг шалган дүгнэж, арга зүйн зөвлөгөө, үүрэг даалгавар өгч ажиллав.

Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд Адаацаг, Хулд, Говь-Угтаал, Дэрэн, Сайнцагаан, Баянжаргалан сумд, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн хэлтэс, Боловсрол соёлын газар, Хүүхдийн төлөө хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийг газар зэрэг олон байгууллагууд санаачилгатай сайн ажилласан байна.Тухайлбал:

- Төрийн бүх байгууллагууд албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, албан хаагчидтайгаа ёс зүйн гэрээ байгуулан тогтмол дүгнэдэг болсон

- Сум, байгууллагууд ажилтнуудынхаа арга туршлага, санал санаачилгыг тооцон дүгнэж, байгууллага бүр “Арга туршлагын сан”-тай болж түүнийг иргэдэд сурталчилдаг болж байна.

- Сайнцагаан, Баянжаргалан, Луус сум, ОБХ, НДХ ,ХХҮХ, Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагууд ёс зүйн зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэн улирал бүр дүгнэдэг

- Сайнцагаан сумын ЗДТГ, Цагдаагийн хэлтэс үйл ажиллагаагаа ил тод сурталчилж, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй хүргэхэд анхаарч иргэдээс санал асуулга, сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийн ажилладаг

- МХГ ТАХ-ийн аймгийн зөвлөгөөний уриалгын биелэлтийг хүн бүрээр гаргуулан дүгнэж, ажил олгогч эздийн холбоотой хамтран “Авилга хүнд сурталтай тэмцэх орон тооны бус хөндлөнгийн зөвлөл” байгуулан ажиллаж байгаа

- НДХ “Байгууллагын үйлчилгээний стандарт” боловсруулан өдөр тутмын үйлчилгээндээ мөрдөж байгаа зэрэг ажлын сайн арга барилууд төрийн үйлчилгээнд хэрэгжиж байна.

- ХХҮХ ТББ-аар зарим чиг үүргээ гүйцэтгүүлдэг,

- Говь-Угтаал сумын бүх төрийн албан хаагчид 3-5 жилийн судалгаатай ажилладаг

- Цагаандэлгэр сумын ЗДТГ ажилтнуудынхаа 7 хоногийн ажлыг өөрсдөөр нь мэдээлүүлж үнэлдэг зэрэг ажлын сайн арга барилууд төрийн үйлчилгээнд хэрэгжиж байна.

Төрийн ажил үйлчилгээний брэндтэй болох талаар зарим сум, байгууллагууд санаачилга гарган ажиллаж байна. Тухайлбал, Луус сум төрийн ажил үйлчилгээгээр, Хулд сум жижиг дунд үйлдвэрлэлээр, Дэлгэрцогт сум “Малчдын талаар төрөөс баримтлах бодлогын загвар сум” болохоор зорин ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, чирэгдэлгүй болгож, үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор аймгийн ЗДТГазарт “Нэг цэгийн үйлчилгээ”-г шинээр нэвтрүүлж, иргэдийн нийтлэг хэрэгцээт нотариат, иргэний бүртгэл мэдээлэл, халамж үйлчилгээ, нийгмийн даатгал, архив, банк, үл хөдлөх хөрөнгийн болон газрын үйлчилгээ зэрэг 8 төрлийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна.

Энэ онд Удирдлагын академийн богино хугацааны сургалтад аймгийн Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, сумдын Засаг дарга нарыг хамруулж, тус сургуулийн дипломын мэргэшүүлэх сургалтад 11, магистрын сургалтад 2 төрийн албан хаагч суралцуулж байна. Энэ онд төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 3 удаа зохион байгуулж явуулсан бөгөөд эдгээр шалгалтуудад нийт 156 иргэн тэнцэж, төрийн албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдэн үүнээс 69 иргэн тухайн албан тушаалд томилогдон төрийн мэргэшсэн албан хаагчдын эгнээг өргөтгөв.

Мөн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг шаардлагатай үед явуулж ирлээ. Эдгээрийн дүнд аймаг, сумын ЗДТГазар, ИТХ-ын ажлын алба, хэлтэс агентлагууд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, ажил эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадвар эзэмшсэн төрийн албан хаагчдаар үндсэндээ хангагдлаа.

“Аймгийн хүний нөөцийг 2001-2010 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд нутгийн боловсон хүчнийг сургаж, бэлтгэх зорилгоор “Аймгийн төрийн байгууллагад шаардлагатай мэргэжилтнийг гэрээгээр сургах журам”-ын дагуу орон нутагт шаардлагатай байгаа эмч, инженер, багш, соёл урлагын ажилтны мэргэжлээр суралцах иргэдтэй гэрээ байгуулж, сургалтын төлбөрийн зохих хувийг аймгаас санхүүжүүлэх арга хэмжээ авч байна.

Аймагт нэн шаардлагатай мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэхэд анхаарч, энэ онд аймгийн Засаг даргын нөөц сангаас 20 иргэний сургалтын төлбөрт 9 сая 214 мянга 700 төгрөгийн санхүүжилт хийгээд байна.

НҮБХХ-ийн төслийн газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд шударга ёс, ил тод байдлыг хангах нь” сэдэвт бүсийн сургалт, ярилцлага зохион байгуулж, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж бэлэн болгоод байна.

Гадаад харицаагаа өргөжүүлэх талаар анхаарч БНСУ-ын Куяан хот, БНУУ-ын Сексард хоттой шинээр холбоо тогтоон хамтран ажиллах гэрээ байгуулж, БНХАУ-ын Хөх хоттой хамтран ажиллахаар төлөвлөгөөний дагуу аймгийн нэгдсэн эмнэлгийн 4 их эмчийг Хөх хотын хятад монгол эмнэлэгт 21 хоногийн хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад, мал зүйч, малын их эмч, бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 10 хүнийг тус хотын Хөдөө аж ахуйн товчоо, Тариалангийн их сургуульд 14 хоногийн сургалтад тус тус хамруулсны дээр Мандалговийн соёл амралтын хүрээлэнд ӨМӨЗО-ны Хөх хотын Сайхан дүүргийн санхүүжилтээр бүжгийн талбай байгуулж ашиглалтад хүлээн авлаа.

Шууд харилцаат Сэлэнгэ аймаг, тус аймгийн сумдтай хамтран ажиллах гэрээний шинэ төсөл боловсруулж солилцсон бөгөөд Дэлгэрцогт сум Сэлэнгэ аймгийн Ерөө

сумтай хамтран ажиллаж сургууль, цэцэрлэг, хүн эмнэлгийн хэрэгцээнд болон иргэддээ эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоогоор ханган ажилласан байна. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт эзэмшилтэй 12 га талбайд Сайнцагаан сумын иргэн Д.Ганбаатар төмс, хүнсний ногоо тариалан 150 тн ургац хураан авч төсвийн байгууллагуудын хэрэгцээнд нийлүүлэв.

Хууль эрх зүйн салбарт Хууль тогтоомжийн сурталчилгааг иргэдэд хүргэн, хэрэгжилтийг хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилт тавьж ажиллалаа.

Сумдад ажиллах “Эрх зүйн хөтөч”-өөр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг бэлтгэж, 28000 гаруй иргэдэд сургалт зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан нь эрх зүйн сургалтыг хүртээмжтэй, үр дүнтэй болгох чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна. Тухайлбал: Луус, Өлзийт сумдын ЗДТГ-аас айл өрх, албан байгууллага, малчин иргэдэд хуулийг сурталчлах зорилгоор шаардлагатай хуулиуд бүхий “**Эрх зүйн хөтөч**” **богц**, “**Гараас гарт, уснаас усанд**” нэртэй аялах хайрцаг сар тутам аялуулдаг, Эрдэнэдалай сум 7 хоног бүр иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулж хэвшжээ.

2009 онд Үйлдвэр худалдааны Сайдын 2005 оны 110 дугаар тушаалыг хэрэгжүүлэн архи, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх 113 цэгийн тоог 87 болгон цөөрүүлж, хяналт, шалгалтыг тогтмолжуулж ажилласаны үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо урьд оны мөн үетэй харьцуулахад 27.8%-иар буурсан байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 73.0 хувьд хүрч, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 247 болж өнгөрсөн оны мөн үеэс 4.62 хувь буюу 12 хэргээр буурсны дотор танхай, залилан, малын хулгайн гэмт хэрэг 27.4-58.3 хувиар буурч, бусдын бие мах бодид гэмтэл учруулсан гэмт хэрэг, хүчин, дээрэм, авто аваарын гэмт хэргийн тоо өссөн байна.

Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх сан 13 суманд бий болж 12.4 сая төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлж, мал сүрэг хамгаалах 212 бүлгэм нөхөрлөл байгуулагдан ажилласан нь мал хулгайлах гэмт хэрэг буурах нөхцөлийг бүрдүүлж байна.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

а/ Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч сайд нараас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

№	Агентлагийн нэр	Нийт бүтээгдэхүүн		Тусгай захиалгат		Өмчлөгчийн эрх		Нийт оноо	Үнэлгээ
		тоо	оноо	тоо	оноо	тоо	оноо		
1	Эрүүл мэндийн газар	52	26.3	17	31.0	3	28.6	85.9	В(Сайн)
2	Биеийн тамир спортын газар	12	19.2	15	25.1	3	24.6	68.9	D (Дутагдалтай)
3	Боловсрол соёлын газар	14	28.6	39	37.1	3	25.8	91.5	А (Маш сайн)
4	Ахмадын хороо	8	27.8	3	35.2	3	27.0	90.1	А (Маш сайн)
5	Нийгмийн даатгалын	4	27.7	3	33.0	3	27.0	87.7	В(Сайн)

	хэлтэс								
6	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс	26	28.1	13	32.5	3	26.0	86.6	В(Сайн)
7	Хүүхдийн төлөө хэлтэс	23	25.6	10	35.8	3	29.0	90.4	А (Маш сайн)
8	Стандарт хэмжил зүйн хэлтэс	5	29.0	1	38.0	2	19	86.0	В(Сайн)
9	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар	31	28.2	11	36.37	3	30	94.47	А (Маш сайн)
10	УЦУОШ-ний алба	9	29.3	11	38.9	3	30	98.2	А (Маш сайн)
11	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	7	28.7	20	35.2	3	27	90.9	А (Маш сайн)
12	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	24.0	11	34.54	7	27.0	85.54	В(Сайн)
13	Цагдаагийн хэлтэс	32	27.2	10	36.3	2	27.5	91.0	А (Маш сайн)
14	Татварын хэлтэс	4	26.1	3	36.0	2	28.5	90.6	А (Маш сайн)
15	Статистикийн хэлтэс	4	30	5	37.0	2	25.5	92.5	А (Маш сайн)
16	Онцгой байдлын хэлтэс	8	26.5	8	35.5	3	28	90.0	А (Маш сайн)
17	Мэргэжлийн хяналтын газар	20	26.7	3	37.3	3	28.2	92.2	А (Маш сайн)
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба	8	27.57	12	36.42	3	27.67	91.66	А (Маш сайн)
19	Шүүхийн шинжилгээний алба	6	25.3	18	34.1	2	27.9	87.3	В(Сайн)
	Дүн	274	26.9	153	35.0	63	27.2	89.1	

Төсвийн ерөнхийлөн захирагч сайд нараас аймгийн засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний биелэлтийн нэгдсэн дүнгээс үзэхэд Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын **63.1 хувь буюу 12 агентлаг “ А “ үнэлгээ** авч, “**А**” үнэлгээ авсан агентлагийн тоо өнгөрсөн оныхоос 6.9 хувиар өссөн байна.

б/ Ерөнхий менежерээс төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Аймгийн ЗДТГ-ын ерөнхий менежер, аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээг ТАЗ-ийн 2002 оны 18 дугаар тогтоолын дагуу аймгийн ЗДТГ-ын хэтийн төлөвлөгөөнд үндэслэн байгуулж хагас, бүтэн жилээр дүгнэн ажиллав.

Аймгийн ЗДТГ, ерөнхий менежерээс 2009 онд байгуулсан гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу Төрийн захиргаа, удирдлагын, Хууль зүйн, Хөгжлийн бодлогын, Нийгмийн хөгжлийн, Санхүү, төрийн сангийн гэсэн 5 хэлтэс, Цэргийн штаб / хуучин нэрээр/ гэсэн бүтэц, 37 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Хэлтэс, ажилтан бүрийн үр дүнгийн гэрээний биелэлтийн хагас, бүтэн жилийн тайланг авч, ярилцлага хийн дүгнэж, урамшуулан ажилтнуудтай мөрөөр нь зохиох ажлыг төлөвлөн ажилласан.

2009 онд аймгийн засаг даргад тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийлүүлбэл зохих 171 бүтээгдэхүүн, 63 тусгай захиалгат бүтээгдэхүүн нийлүүлэхээр

гэрээ байгуулан ажилласан. Аймгийн Засаг дарга, Ерөнхий менежер 2009 оны үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, “**Ерөнхий менежерийн үүрэгт ажлыг маш сайн гүйцэтгэн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажилласан, өгсөн үүргийг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэг. Засгийн газрын ХЭГ-ын үзлэг, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэгт “А” үнэлгээтэй шалгагдсан**” хэмээн дүгнэжээ.

2009 оны эцэст гэрээг дүгнэхэд нийт бүтээгдэхүүний нийлүүлэлтийн дундаж оноо 28.2, тусгай захиалгат бүтээгдэхүүний нийлүүлэлт 38.3, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх зорилтын биелэлт 29.5 оноотой дүгнэгдэж, авбал зохих 100 онооноос **96.0 оноо авч “А” буюу “маш сайн” үнэлгээ** авсан байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн үр дүнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн гарааны жилд **аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилт 92.9 хувьтай** байна гэж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаас дүгнэж **Засаг даргын үйл ажиллагааг “Бүрэн хангалттай”** гэж үнэлсэн юм.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүх шатанд хангуулах талаар анхаарч хагас жил дутам шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгаад сум байгууллага бүрээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөгөө, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 98.5 хувь, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг 96.6 хувь, төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг 97.1 хувь, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг 96.0 хувь хангаж, **нийт дүнгээрээ 4.85 гэсэн үнэлгээтэйгээр шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа дүнтэй** байна. Шалгуур үзүүлэлтийг аймгийн хэмжээнд хэрхэн хангаж буй талаар дэлгэрэнгүй мэдээллийг тайланд хавсаргав.

Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд шударга ёс, ил тод байдлыг хангах” аймгийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт, ярилцлагыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төсөлтэй хамтран аймагтаа зохион байгуулж, “Шударга ёс, ил тод байдлыг хангах” аймгийн төлөвлөгөөнд бодлогын 6 зорилт бүхий 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Уг төлөвлөгөөг ЗГХЭГ, АТГ-т тус тус хүргүүлж одоо сум, байгууллагын түвшинд төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих нэгжийг байгуулан ажиллаж байна.

Энэ онд Засгийн газрын 143 дугаар тогтоолын “Ил тод байдлаар шалгуур үзүүлэлт”-ийг ханган ажиллахад ихэнх байгууллагууд санаачилгатай ажиллаж төрийн байгууллага, албан хаагчдын чиг үүргийг ил тод тавьж, үйл ажиллагааны ил байдлыг хангаж, ТАХ-ийн ямар ажил хариуцдаг, иргэдээс хэнд ямар асуудлаар хандах талаар

иргэд мэдээлэл авч болохуйцаар байрлуулж сурталчилсан, нээлттэй утас ажиллуулж иргэдээ сонсдог болсон, тогтоолын хэрэгжилтийг тухайн байгууллагын ажлын шалгуур үзүүлэлт болгон дүгнэж байгаа зэрэг ажлын сайн эхлэлүүд байна

Эрдэнэдалай сум, аймгийн ЗДТГ, Татварын хэлтэс, НДХ, зэрэг байгууллагууд “Нэг цэгийн үйлчилгээ” нээр ажиллуулж байгаа нь төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, үйлчилгээний чанар хуртээмжийг сайжруулахад ач холбогдолтой ажил болж байна.

Түүнчлэн энэ хугацаанд Дэрэн сумын дунд сургууль дотуур байрандаа хүүхдийн хөгжих, тоглох орчин бүрдүүлж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн “Нэг цэг”-ийн үйлчилгээ бий болгосон байна.

“Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага-манлайлал” аймгийн зөвлөгөөнөөс гаргасан уриалга, аймгийн Засаг даргын албан даалгаварыг хэрэгжүүлж, Сайнцагаан, Эрдэнэдалай, Луус, Өлзийт зэрэг сумд, МХГ, БСГ, Цагдаагийн хэлтсийн хамт олон төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулж, ОБХ, МХГ, ХХҮХ, Цагдаагийн хэлтэс, ШШГА, Баянжаргалан, Сайнцагаан, Говь-угтаал, Луус, Адаацаг сумдын төсвийн байгууллагууд ёс зүйн зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэн үр дүнг тооцон ажилласан байна.

Зөвлөгөөний шийдвэрийн хүрээнд Нийгмийн даатгалын хэлтэс “Байгууллагын үйлчилгээний стандарт” гарган хэрэгжүүлж, МХГ “Авилга хүнд сурталтай тэмцэх орон тооны бус зөвлөл” байгуулан ажиллаж байгаа, сум, байгууллагын 80 гаруй хувь нь “Нээлттэй утас” ажиллуулж хэвшсэн, ЭМГ салбарынхаа хэмжээнд “Сайн туршлага сан” нээн баяжуулж харилцан туршлага солилцох нөхцлийн бүрдүүлсэн олон талт ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүлсэн байна.

“Нээлттэй хаалганы болон мэдээллийн өдөр”-үүдийг сум байгууллагын хэмжээнд графикайн дагуу тогтмол зохион байгуулж иргэдээр байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдал, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид үнэлгээ өгүүлэх, тэдний санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах, өөрсдийн үйл ажиллагааг нээлттэй ил тод болгож сурталчлах арга хэмжээ тогтмол авч ажиллаж байна.

ИНБ төлөөлөлтэй хамтран ажиллах талаар уулзалт, ярилцлага зохиож, Засаг даргын зөвлөлд ТАС зөвлөлд ИНБ-ын төлөөллийг оролцуулж, төрийн байгууллагын ажил үйлчилгээний чанарт судалгаа хийлгэх, ТАХ-ын мэргэшлийн шалгалтад хяналт тавиулах зэргээр хамтран ажиллаж байна.

Төрийн байгууллага бүр үйл ажиллагааныхаа жил улирлын төлөвлөгөөнд “Иргэдээс ирүүлсэн СӨГ-ыг шийдвэрлүүлэн ажиллах талаар” тусгай бүлэг болгон тусгаж, хэрэгжилтийг тооцдог. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан санал, өргөдөл, гомдлыг амаар, бичгээр, утсаар, И-мэйлээр шуурхай хүлээн авах байдлыг хангаж ажиллаж байна. 2009 онд аймгийн хэмжээгээр нийт 16676 захидал, үүнээс амаар 4413, бичгээр 11908, утсаар 2, хурал цуглаанаар 353-ыг хүлээн авч байна. Санал 2261, өргөдөл 14163, гомдол 252 байна. СӨГ-ын шийдвэрлэлт 100% байна.

ОБХ, ХХҮХ, ЭМГ, Адаацаг, Говь-Угтаал, Луус, Сайнцагаан сумд төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн СӨГ-ыг бүртгэл хяналтад авч хариуг хугацаанд нь 90-

ээс дээш хувьтай шийдвэрлэж байгаагаас гадна бүх сум, байгууллага “Нээлттэй утас”-аар ч бас санал хүсэлт гомдлыг хүлээн авч бусдыгаа манлайлж байна.

Төрийн байгууллагуудаас шийдвэр гаргахдаа иргэд, хэрэглэгчдээр хэлэлцүүлэн тэдний санаа бодлыг гаргаж байгаа шийдвэртээ тусгах талаар анхааран ажилласан байна.

Тухайлбал, Төрийн алба, үйлчилгээний талаар бүх сумдыг хамруулан иргэдээс хуудсаар санал асуулга авч нэгтгэн дүгнэж аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөнд гарсан саналуудыг тусгасаны зэрэгцээ тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдал, хүнд суртал чирэгдэл, албан хаагчдын үйлчилгээний талаар аймгийн ИНБ-ын Сүлжээтэй хамтран ТББ-аар иргэдээс санал, асуулга авч нэгтгэн иргэдээс гарсан санал, шүүмжлэл, хүсэлтийг “Шударга ёс, ил тод байдлыг хангах аймгийн” төлөвлөгөөнд тусгасан байна.

Тав. Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээгээр **5.76 оноо** авсны дотор эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт 6.51, нийгмийн үзүүлэлтийн үнэлгээ 5.44, хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ 5.33 байна.

Төрийн алба, үйлчилгээний талаар 4 чиглэлээр өөрийн аймгийн онцлог байдлыг тусгасан санал асуулгын хуудас боловсруулан нийт сумдын 394 иргэнийг хамруулан хариулт авч нэгтгэн дүгнэв. Санал асуулгын нэгдсэн дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг тайланд хавсаргав.

4 чиглэлээр авсан санал асуулгын дүнгийн дундчаар 3.9 оноо авсан байна

Хууль тогтоомж, Засгийн газрын болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийн талаар иргэдээс хууль тогтоомжийн мэдээлэл, сургалт сурталчилгаа, хэрэгжилтийн байдлын талаар санал асуулгад оролцогсдын 31.9-41.9 хувь нь бүрэн хангалттай, хангалттай, 5.8-23.6 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсан, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны шударга байдлын асуулт тавьж хариулт авахад 23.6-27.1 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 14.2-27.1 хувь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулжээ.

Хууль тогтоомж, Засгийн газрын болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтээр 3.74 онооны үнэлгээг иргэд өгсөн байна.

Дээрх хариултаас үзэхэд хууль тогтоомж шийдвэрийн сургалт сурталчилгааг сайжруулах, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны шуурхай шударга байдлыг хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд өнөөгийн Засгийн газрын үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгаа, ядуурлын бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний чанар хүртээмж, үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн ажлын үр дүнгийн талаар 3 асуулт тавьж хариулт авахад санал асуулгад оролцсон

иргэдийн 28.6-36.8 хувь нь өнөөгийн Засгийн газрын үйл ажиллагааг хангалттай, бүрэн хангалттай ,9.6-20.5 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үнэлсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээр 3.82 оноо авсан байна.

Ядуурлын бууруулж өрхийн орлогын нэмэгдүүлэх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг санал асуулгад оролцсон иргэдийн 27.6-43.4 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үзсэн бол 22.3 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж дүгнэсэн байна. Үүнээс үзэхэд иргэдийн ядуурлын бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар авч байгаа арга хэмжээг нааштай үнэлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Харин үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн ажлын үр дүнг санал асуулгад оролцсон иргэдийн 74.6 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлж дүгнэсэн бол 20 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үзсэн байна.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр 4 асуулт тавьж хариулт авсаны дотор үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт сумдад хэр зэрэг байгаа талаар иргэдээс асуухад иргэдийн 78.6 хувь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлсэн бол 19 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхэд аймаг, сумдын Засаг дарга нарын хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтэд иргэд илүү сэтгэл ханамжтай байдаг нь харагдаж байна.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээр 4.0 оноо авсан байна

Тус аймагт 2009 онд дэвшүүлэн тавьсан “Төрийн албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн байдалд санал асуулгад оролцсон иргэдийн 79.4 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлж дүгнэж байгаа бол 15.2 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсан байдлаас үзэхэд энэ ажил зохих үр дүнгээ өгчээ гэж үзэж болохоор байна.

Мөн тус аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Өрх бүр үйлдвэрлэгч-үйлчлэгч -II” хөдөлгөөн хэрхэн өрнөж байгаа байгаа талаар болон сумдад төмс, хүнсний ногоо хэр зэрэг тариалж байгаа талаар иргэдээс асуухад иргэдийн 78.3-79.1 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 8.9-9.6 хувь нь төдийлөн хангалттай бус, 8.6-9.4 хувь нь хангалтгүй гэж хариулснаас үзэхэд энэ хөдөлгөөнийг илүү өргөн хүрээнд олны хамруулан эрчимтэй зохион байгуулах төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх шаардлагатай шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Аймаг, сумын Засаг даргаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмж хэр зэрэг байгаа талаар дараах 4 асуултад хариулт авахад:

Сумдын төрийн байгууллагуудад ил тод, шударга байдал хэрхэн хангагддаг талаар иргэдээс асуухад 34.5-37.5 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 6.8-17.0 хувь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулжээ. Харин Та хүссэн үедээ эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авч чадаж байна уу гэсэн асуултад санал асуулгад оролцогсдын олонх нь буюу 81.9 хувь нь хариулсанаас үзэхэд

тус аймгийн эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх талаар сайн ажиллаж ирснийг харуулж байна.

Тус аймагт иргэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хэрхэн хангагдаж буй талаар асуухад санал асуулгад оролцсон иргэдийн 32.2-47.9 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 16.5 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулснаас үзэхэд стандартын шаардлага хангасан эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр цаашид хангах талаар анхаарах шаардлага хэвээр байгаа нь харагдаж байна.

Сумдын ариун цэвэр тохижилтын талаар иргэдээс асуухад иргэдийн 27.1-51.8 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 18.2 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсанаас үзэхэд өнгөрсөн онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд туссан сумдын төвийн ариун цэвэр, тохижилтыг сайжруулах талаар хүлээсэн үүргээ сумдын Засаг дарга нар биелүүлэх талаар багагүй санаачлага гарган ажиллаж ирсэн нь харагдаж байна.

Аймаг, сумын Засаг даргаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжид иргэд 3.98 оноо өгсөн байна.

Түүнчлэн энэ удаагийн санал асуулгаар аймгийн 70 жилийн ойгоо угтаж орон нутгийнхаа хөгжлийг урагш ахиулах, малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тус аймагт нүүрлээд байгаа цөлжилтийг сааруулах талаар ямар ямар ажил хийгээсэй гэж хүсч байгаа талаар иргэдээсээ асууж хариулт авч цаашдынхаа ажилд тусгах талаар анхаарч байна. Иргэдээсээ гарч байгаа саналуудыг хэрэглэгчийн үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгалаа.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний 2009 тайланг өнгөрсөн оны 1 дүгээр сард хүргүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагч сайдаас аймгийн Засаг даргатай 2009 онд байгуулсан гэрээний биелэлтийн нэгдсэн дүнг хүснэгтээр тайлан дотор тусгагдсан, ТЕЗ аймгийн Засаг даргаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн талаар мөн тайлан дотор бүлэг болгон бичсэн тул тусад нь тайланд хавсаргаагүй болно.

Тайланд дараах материалуудыг хавсаргав.

1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан / аймагт холбогдох заалтаар/
2. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан / аймагт шууд холбогдох арга хэмжээ нэг бүрээр/
3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан / аймагт холбогдох заалт бүрээр/
4. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт / заалт нэг бүрээр/
5. Аймагт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан
6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан /заалт нэг бүрээр/

7. Үйл ажиллагааны ил тод байдлын дэлгэрэнгүй мэдээлэл / Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлт бүрээр/

8. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт/ журмын 4 дүгээр хавсралтаар өгөгдсөн хүснэгтээр/

9. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээний дүн / журмын 3 дугаар хавсралтаар өгөгдсөн хүснэгтээр /

10. Санал асуулгын нэгдсэн дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

ТАЙЛАН БИЧСЭН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

/ Ш.ТӨРБАТ/

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

/ Л.ЦЭВЭЭНРАВДАН/

Журмын 3 дугаар хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2009 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	82.7	4.13
		2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	92.1	4.6
		3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	92.3	4.62
Үнэлгээний дундаж оноо			4.45	
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	96.2	4.81
		2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	84.8	4.24
		3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	98.8	4.94
		4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	95.7	4.79
Үнэлгээний дундаж оноо			4.7	
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	89.1	4.45
		2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	96.0	4.8
Үнэлгээний дундаж оноо			4.63	

4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	98.5	4.92
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	96.6	4.83
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	97.1	4.85
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	96.0	4.8
Үнэлгээний дундаж оноо				4.85
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	5.76	5.76
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	3.9	3.9
Үнэлгээний дундаж оноо				4.83
Ерөнхий үнэлгээ				4.7

---oOo---

